



**СҮХБААТАР ДҮҮРЭГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

14190 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
7 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Денверийн гудамж-13  
Утас: 70070109 Факс: 70070113  
<http://www.sbd.ub.gov.mn> E-mail: [info@sbd.gov.mn](mailto:info@sbd.gov.mn)

2019. 06. 21. № 7/1585

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ДЭРГЭДЭХ  
ХЭЛТЭС, АЛБАДЫН ДАРГА НАРТ**

Иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах эрхийг хамгаалах аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Цэвэр цэмцгэр Сүхбаатар дүүрэг аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээний арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 11 цагт нэгдсэн байдлаар зохион байгуулна.

Иймээс цэвэрлэгээний ажилд ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж идэвхтэй оролцуулж ажлын тайланг 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 15 цагаас өмнө Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст ирүүлнэ үү.

Хавсралтаар Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 01/09 дүгээр албан даалгаврыг хүргүүлэв.

Хавсралт ... хуудастай.

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭДМОН

1140201196



СҮХБААТАР ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 01/09

Улаанбаатар хот

□ Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах □

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам батлах тухай 63 дугаар тогтоол, 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам батлах тухай 61 дүгээр тогтоол, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 05 дугаар сарын 20-ны А/145 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Аян зохион байгуулах тухай А/61 дүгээр захирамж, 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай А/265 дугаар захирамжийг үндэслэн ДААЛГАХ нь:

2019 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, сургууль, цэцэрлэг орчны 50м зам талбайн хөл газрын ургамлыг зулгаах, ногоон байгууламж, явган хүний замыг цэвэрлэх, хашаа хайс, хаалга, хаягжилт, цонхоо угааж, засварлах, гэрлийн шон дээрх зарлал, сурталчилгааны хуудсыг хуулж цэвэрлэх, үйл ажиллагааг зохион байгуулж тайланг фото зургаар баримтжуулан 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 15:00 цагийн дотор албан бичгээр дүүргийн Засаг даргын Тамгын газарт болон Хорооны Засаг даргын ажлын албанд, файлаар бол [sbdtnaah@yahoo.com](mailto:sbdtnaah@yahoo.com) хаягаар ирүүлэхийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад даалгасугай. Харилцах утас: 70070125.

Албан даалгаврыг хангалтгүй биелүүлсэн болон биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авах болно.

ЗАСАГ ДАРГА



Х.БОЛОРМАА

1140200016